

Хэсэг 9

Монгол дахь бурханы шашин ба Их Майдар цогцолбор төсөл

Мишиг-Ишийн Батаа

Редакторын тайлбар: Зөвлөлтийн үед 1250 орчим сүм хийд, хурлын газрыг шатааж устган, Монголын соёл, шашны өвийг сүйтгэснийг сэргээх үүднээс М. Батаа Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын ойролцоо томоохон хэмжээний Их Майдар бурханы цогцолбор байгууламжийг бүтээж босгохоор төлөвлөж буйгаа бидэнд танилцуулсан. Уг төсөл нь хувийн аж ахуй, хэвшилүүдээс санхүүгийн эх үүсвэрээ хангаж буй бөгөөд 40 метр өндөртэй Чингис хааны (дэлхийн 16 дахь) хөшөөг амжилттай байгуулж босгосон арвин туршилагатай баг ажиллаж буй ажээ. 108 метр өндөртэй байхаар төлөвлөж эхлүүлээд буй суварга бүхий Их Майдар нь Япон, Хятад, Бирма улсуудад буй бурхан багшийн их сэрэг дүрийн дараагаар дэлхийд 4 дүгээрт бичигдэх өндөр хөшөө дурсгал болох юм. Бурхан баги, бурханы шашинтай холбогдох өөрсдийн холбоог харуулахыг эрмэлздэг Азийн олон улс орнуудын дунд Монголчууд өөрсдийгөө онцгой байр суурьтай хэмээн үздэг. (Цор ганцаар устгагдалгүй үлдэж хоцорсон байсан Монголын бурханы шашны гол хийд Гандан дахь 1913 онд бүтээгдсэн, 26 метр өндөр Бурханы энэрэн нийгүүлсэхүйн дүр Жанрайсиг нь дэлхий дээрх төмөрлөгөөр хийсэн хамгийн өндөр хөшөө дурсгал байж болох юм.) Одоо хэрэгжиж буй Их Майдар бурханы цогцолбор байгуулах төсөл нь бурханы шашны сүм, бясалгал, бүтээлийн газар, өндөр технологи бүхий, байгаль экологид ээлтэй эрчим хүчний байгууламж, зочид буудал, худалдааны төв, теннисний талбай, аялал жуулчлал, амралт зугаалга, цэцэрлэгт хүрээлэн бүхий шашин шүтлэгийн төв, технологийн гайхамшигийг хослуулсан цогцолбор байх ажээ. Хувраг асан М. Батаа нь энэхүү төслийн зөвлөмж удирдлага, санхүү аль альны нөхцлийг хангах үүрэг хүлээн ажиллаж буй юм. Өргөн утга агуулгаар

авч үзвэл энэхүү төсөл нь Монголчуудад өнөөдөр тулгараад буй сорил, бэрхшээл, альтернатив сонголтын тусгал хийгээд эдийн засгийн өсөлт, орчин үежилт, гадны нөлөө зэргийг хэрэглэж өөрийн онцлогтой үндэстэн, соёл, шашны ижилслээ дахин бүрдүүлж, баталж буй хэрэг хэмээн үзэж болох билээ.

Түүхээс үзвэл, бурханы шашныг Монголд 2000 жилийн өмнө Төв Азийн Торгоны замын наймаачид анх оруулж ирсэн ч өргөн дэлгэрлийг олоогүй. Хожим XIII-XIV зуунд бурханы шашин сурвалжит гэр бүлүүдийн хүрээнд тархаж байсан удаатай. Харин XVII зуунд бурханы шашин тэр үеийн Монголчуудын гол шашин болсон юм.

Коммунист үзэл суртал, социалист дэглэмийн 1930-аад онуудад явуулсан лам хуврагуудыг хороон, сүм хийдүүдийг нурааж, судар тахилыг галдан шатаах ажиллагааны үр дүнд бурханы шашин устахад хүрсэн юм. Харин 1990 онд болсон ардчилсан хувьсгалын ачаар нийгэмд өөрчлөлт шинэчлэл ирж, бурханы шашныг Монголчуудын уламжлалт соёлын үндэс, мөн ардчилсан нийгэм дэх шашин шүтэх эрх чөлөөний илрэл хэмээн сэргээж байгаа билээ.

Өнөөдөр бурханы шашин Монголчуудын дунд хамгийн өргөн дэлгэрсэн, Төвдийн бурханы шашинтай төстэй олон ижил шинжээ хадгалсаар байгаа шашин юм. Зарим эх сурвалжийн тооцоолсноор Монголчуудын 70-80 хувь нь бурханы шашинтай ажээ. Одоо Монголд таван гол том сүм хийдийн зэрэгцээ хэд гурваас авахуулаад хэдэн арван лам хуврагтай дунд болон жижиг сүм, дацан олон арваараа байгуулагдаад байна. Мөн Улаанбаатар хотод ани (эмэгтэй хувраг) нарын хийд хэд бий.

Томоохон сүм, хийдүүд лам хуврагуудаа өөрсдөө сурган, боловсрол олгодог. Өнөөдрийн байдлаар гурван том сүм хийдийн дэргэд байгуулагдсан бурханы шашны нэг дунд сургууль, гурван дээд сургууль Улаанбаатар хотод ажиллаж байгаагийн зэрэгцээ мөн Энэтхэгт 300 гаруй лам хувраг суралцаж байна. Монголд өнөөдөр нийт 2500 лам хувраг бий.

УИХ 2004 онд “Төр, сүм хийдийн харилцааны тухай”

хууль батлан гаргасан бөгөөд энэ хуулиар улсын бүртгэлд бүртгүүлсэн шашны байгууллага татвараас чөлөөлөгдөхөөр болсон юм. Шашны байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хийд байгуулан ажиллуулах зөвшөөрөл авсан байх зохицуулалттай байна.

“Их Майдар цогцолбор” төслийн тухай

Монголд бурханы шашны соёл, боловсролыг сэргээн хөгжүүлэх зорилгоор “Их Майдар Сан”-г 2010 оны 9 дүгээр сард үүсгэн байгуулсан билээ. Уг байгууллагыг Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд төрийн бус байгууллагын статустай сан хэмээн бүртгээд байгаа юм. Сангийн үндсэн үйл ажиллагаа нь бурханы шашны соёл, боловсролын үйл ажиллагааг дэмжин дэлгэрүүлэх, боловсролын зорилгоор ном хэвлэхийг дэмжих, уламжлалт соёлын үнэт зүйлсээ хадгалан өвлүүлэх зорилгоор соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаадын бурханы шашны байгууллагуудтай хамтран ажиллах, Монголын түүхэн дэх Бурханы шашны хамгийн том цогцолбор болох Их Майдар цогцолборыг барих төслийг хэрэгжүүлэх зэрэг болно. “Их Майдар цогцолбор” төсөл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжиж байна.

“Ирээдүйн Ундраа Сан” болон уг төслийн хэрэгжүүлэгч байгууллага болох “Их Майдар сан”-аас хамтран санаачилсан Их Майдар цогцолбор нь тайван, амгалан орчинг бүрдүүлсэн онцгой нэгэн цэцэрлэгт хүрээлэн болох юм. Уг цэцэрлэг нь Улаанбаатар хотын захад буюу хотын чимээ шуугианаас холдож гэр бүлээрээ бүтэн өдрийг өнгөрөөхөд нэн тохиромжтой байршилтай юм.

Мөн түүнчлэн Их Майдар цогцолборын гол зорилго нь Монголын оюун санааны баялаг өвийг улам тодруулах замаар өнө эртнээс улбаатай Монголын Бурханы шашны түүхийг

хадгалан үргэлжлүүлэх явдал юм. Энэ утга санаагаар дээрх хоёр сан нь хувийн салбарын санаачилгыг дэмжин, 54 метрийн өндөртэй Майдар бурхан бүхий 108 метрийн өндөртэй суваргыг барьж байгуулах ажилд оролцож байгаа билээ.

Зөвлөлтийн хяналт дор орохоос өмнө Монгол улс бурханы шашнаар дамжуулан олж авсан үнэ цэнэт зүйлс, алдар нэрийнхээ хэсгийг ч болов сэргээх цаг ирлээ хэмээн зарим Монгол хүн сэтгэл зүрхэнийхээ угаас итгэх болжээ. Монголд эртний уламжлалт олон сүм, хийд байсан нь социализмын үеэд устгагдан үгүй болж, одоо үлдээд байгаа цөөн хэд энгийн хүнд хүртгээмжгүй болжээ.

Монгол бол бурханы шашны гүн гүнзгий утга учир шингээсэн зан үйл, оюун санааны уламжлалыг хадгалсан баялаг уламжлалтай орон. Тиймээс Их Майдар цогцолбор нь Монголд бурханы шашныг сэргээх, магадгүй үүнээс ч илүүтэйгээр уул уурхайн олборлолтоос үүссэн огцом өсөлтийн эхлэл болсон энэ үед эрүүл, зөв үнэт зүйлсийг сурталчлан таниулах төгс төгөлдөр арга хэрэгсэл нь энэ цогцолбор юм. Энэ талаасаа Их Майдар цогцолборын байршил нь түүний ач холбогдлыг нэмэгдүүлж буй удаах хүчин зүйл юм. Улаанбаатар хотын захад байрлаж байгаагаараа энэ цогцолбор нийслэл хотын оршин суугчдад өөрсдийн соёл, байгалийн үнэт өв болсон Богд хаан ууландаа ирж цагаа өнгөрөөх боломж олгож байна. Энэ төслийн гол санаа нь Монголчуудаа нэгэн дор цуглуулж, нэгтгэн нягтруулах хүсэл эрмэлзлээс үүдэлтэй тул төсөл хэрэгжсэний үр дүн хүмүүс цэвэр агаарт, байгалийн сайханд дуртай хүмүүстэйгээ цагийг сайхан өнгөрөөж, аялж зугаалан, урлаг спортоор хичээлэх боломжоор хангагдах юм. Мөн энэхүү цогцолбор нь бурханы шашныг судлах сонирхлыг өдөөн сэргээж, Бурхан багшийн номлол сургаалыг олон олон хүн шимтэн судалж, амар амгалан хийгээд утга төгөлдөр амьдрах хүсэл тэмүүлэлтэй болгоно гэж найдаж байна.

Их Майдар цогцолборын гол хэсэг нь уулын оройд байрлах 54 метрийн өндөртэй Бурхан багшийн ирээдүйн дүр Майдар бурханы хөшөө, 108 метрийн өндөртэй суварга байх юм. Майдар бурханы хөшөөнд хүрэхийн тулд хоёр талаар нь

цэцэрлэгт байгууламж бүхий шатаар гарна. Цогцолборын төвд уран хийцтэй усан оргилуур байх бөгөөд бусад байгууламжууд цогцолборын эзэмшил талбай даяар урьднаас сонгож авсан газарт байрлах юм. Төрөл бүрийн сүм хийд, өргөөнүүд, олон улсын сүм хийдийн хэсэг, зочдод йога, бясалгал, урлагийн хичээл заах мэдлэгийн өргөө, бясалгалын өргөө, задгай театр, кинотеатр, олон улс орны болон монгол хоолоор дайлах зоогийн газар, бизнес үйлчилгээний төв, худалдааны төв, зочид буудал, банк, аялал жуулчлалын үйлчилгээний төв зэрэг нь энэ цогцолборт багтана.

Их Майдар цогцолбор нь Монгол болон бүс нутагтаа байгаа соёл, шашны төвүүдээс ялгарах өөрийн гэсэн өвөрмөц шийдэл, онцлог үзэл санааны ачаар олон янзын учир шалтгаанаар янз бүрийн зочин гийчдийг татсан их хөлийн газар болно гэж найдаж байна.